

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ БОЛОВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит бус хурал 2014 оны 4 дүгээр сарын 16-нд хуралдаж, “Монголбанкны захиргаа, аж ахуйн зардал, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 2013 оны гүйцэтгэлтэй танилцсан тухай” асуудлыг хэлэлцэв.

Монголбанкны удирдлагын зүгээс системийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирч 2013 оны төсвийн зардлыг төрөл бүр дээр хэмнэсэн байна.

2013 оны орлого, зарлага, хөрөнгө оруулалтын байдалд гарсан нааштай өөрчлөлтийг Хяналтын зөвлөлийн хурлаас сайшаан тэмдэглэж, захиргаа, аж ахуйн төсөв, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй танилцсан дүнг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо болон Монголбанкны удирдлагад хүргүүлэхээр тогтов.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ